

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА**

(2025 оны жилийн эцсийн байдлаар)

2025.12.19

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээний зорилго, үндэслэл, арга зүй

Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнд хүрэх явцыг тогтмол хугацаанд ажиглан зөв чиглүүлэх, үр дүнг хэмжих, бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, төрийн байгууллагын хүлээх үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, ил тод байдлыг хангахад хяналт-шинжилгээний зорилго оршино.

Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлтэд хүрсэн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ыг үндэслэл болгов.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.1, 6.3, 6.5 - д заасан аргачлалыг удирдлага болгов.

Хоёр. Хяналт-шинжилгээний үр дүн

Монгол Улсын Их хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин”-г баталж, Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт” тус тус батлагдсан.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (ЗГҮАХХАХТ¹)-нд тусгагдсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хариуцан хэрэгжүүлэх **2 бодлогын 2 тэргүүлэх зорилтын 5 арга хэмжээг** хяналтад авч, хэрэгжилтийн тайланд явцын хяналт-шинжилгээ хийв.

Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Эдийн засгийн бодлого 3.1.2.4.485, Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого 4.1.4.2.1063, 4.1.4.2.1064, 4.1.4.2.1065, 4.1.4.2.1066 дугаар арга хэмжээнүүд, 2 дугаар хавсралтаар батлагдсан ЗГҮАХХАХТ-ний үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд төсвийн ерөнхийлөгчийн захирагчийн үр дүн – 1 (3.1.2.4, 4.1.4.2), хөтөлбөрийн үр дүн – 3 (3.1.2.4, 4.1.4.2, 4.1.4.2) нийт 4 үр дүн тусгагдсан байна.

Үнэлгээний дүнгийн товч танилцуулга:

Бодлого, арга хэмжээгээр харуулбал:

- Эдийн засгийн бодлогын 1 зорилтын 1 арга хэмжээний хэрэгжилт 90.0 хувь;
- Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын 1 зорилтын 4 арга хэмжээний 1 арга хэмжээ (4.1.4.2.1066) нь хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй (2026 он) бөгөөд 3 арга хэмжээний дундаж үнэлгээ 100.0 хувь.

¹ Товчилсон үсгийн тайлал: ЗГҮАХХАХТ – Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Засгийн газрын 2024-2028 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2025 оны жилийн эцсийн тайлангийн хэрэгжилтийн явцын зорилтот түвшин дунджаар – **90.0% буюу “Үр дүнтэй”**-гээр дүгнэгдэж байна.

Үндсэн хэрэгжүүлэх нэгжээр нь харуулбал:

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Зорилтот түвшин (2025 он)	Хүрсэн түвшин (2025.07.01)	Хариуцах хэлтэс	Үнэлгээ	Тайлбар
ЗГҮАХХАХТөлөвлөгөө						
1	3.1.2.4.485	10	-	ТӨУЗХ	90 хувь	Биржээр олон нийтэд нээлттэй худалдах хуулийн этгээд (хувиар)
2	4.1.4.2.1063	100	-	Бүх хэлтэс	100 хувь	Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх (хувиар)
3	4.1.4.2.1064,	1500	3500	Бүх хэлтэс	100 хувь	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо
4	4.1.4.2.1065	60	83.3	Бүх хэлтэс	100 хувь	Систем хөгжүүлэлтийн хувь
5	4.1.4.2.1066	2026 онд хэрэгжинэ		ТӨБАХ		
ЗГҮАХХАХТөлөвлөгөөний үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт						
Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн						
1	3.1.2.4 4.1.4.2	2	2.20	ТӨУЗХ	100 хувь	Зорилтот түвшинг тодорхойлсон тайлбарт тусгасны дагуу "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн цэвэр ашиг, хөрөнгийг хасаж төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хөрөнгийн өгөөж тооцсон дүн
Хөтөлбөрийн үр дүн						
1	3.1.2.4	4	-	ТӨУЗХ	Х/Б	УИХ-ын 2022 оны 16 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-д үндэслэн тодорхойлсон зорилтот түвшин. "Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн

						газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д тогтоолын төслийг өргөн барихаар тогтсон. Иймд дээрх үндсэн чиглэл батлагдахаар хүлээгдэж байна.
2	4.1.4.2	2026 онд		ТӨБАХ	Х/Б	
3	4.1.4.2	82	82	ТӨХШХ	100 хувь	Хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилт хувиар

Гурав. Дүгнэлт

2025 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 2 бодлогын 2 зорилтын 4 арга хэмжээний хэрэгжилтийн явцын зорилтот түвшин дунджаар – **97.5% буюу “Үр дүнтэй”**, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшингийн биелэлтийн дундаж **100.0% буюу “Үр дүнтэй”**-гаар тус тус дүгнэгдэж байна.

3.1.2.4.485. "Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д тогтоолын төслийг өргөн барихаар тогтсон. Иймд уг арга хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хамаарсан асуудлыг гүйцэтгэсэн гэж үзээд 90 хувиар;

4.1.4.2.1063. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай (Нийтийн өмчийн хууль болон нэр өөрчлөгдөж) хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалыг сайжруулахад чиглэсэн анхдагч хуулийн (Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай анхдагч хууль нэртэйгээр) төслийг боловсруулж, Засгийн газраас УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо, улмаар Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар тус тус хэлэлцэн дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн Байнгын хороонд шилжүүлсэн. Иймд уг арга хэмжээг 2025 оны зорилтот түвшинг хангасан гэж үзэн 100 хувиар дүгнэсэн болно.

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хөтөлбөрийн үр дүнд тусгагдсан 3.1.2.4 дэх арга хэмжээ нь УИХ-ын 2022 оны 16 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-д үндэслэн тодорхойлсон зорилтот түвшин байсан тул 2025 онд уг үр дүнг хэрэгжүүлэхээр "Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д тогтоолын төслийг өргөн барихаар тогтсон. Иймд дээрх үндсэн чиглэл батлагдахаар хүлээгдэж байгаа тул "хугацаа болоогүй"-ээр дүгнэсэн болно.

Дөрөв. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал /Зөвлөмж/

- Тайлангийн хэрэгжилтийг зөвхөн 2000 тэмдэгтэд багтаан гарсан үр дүнг тайлагнаж байх

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА Б.ЦЭНГЭЛ

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Н.ГАНБОЛД

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
МЭРГЭЖИЛТЭН Д.ЦЭРЭНЛХАМ